



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2023 СУУРЬ БОЛОВСРОЛ



МОНГОЛ ХЭЛ

ХУВИЛБАР В

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:



Санамж:

- ✓ Монгол хэл, үндэсний бичиг, уран зохиолын 20 даалгаврыг 40 минутад гүйцэтгэх тул цагаа сайтар төлөвлөж бүх даалгаврыг ажиллаарай.
- ✓ Монгол хэлний даалгавруудыг гүйцэтгэхдээ эхийг уншиж, сайтар ойлгосон байхыг анхаараарай.

Инээлдсэн нь

Тооны хичээл дээр бичгийн ажил хийх болжээ. Гэтэл Туяагийн дэвтэр дүүрчихсэн байв. Туяа нэг ширээний Болдоос дэвтэр гуйхад Болд цүнхнээсээ гурван шинэ дэвтэр гаргаад нэгийг нь өгөхдөө “Чи надад тоогоо хуулуулаарай” гэж аяархан хэлжээ. Туяа “Баярлалаа! Би маргааш авчирч өгнө өө” гэснээс ондоо юм хэлсэнгүй. Хүүхдүүд дор бүрнээ тоогоо бодон суухад ганцхан Болд л багш руугаа харсаар сууна.

Тэр багшийгаа юм бичихээр тонгойх зуур Туяа руу хазайж “Нааш нь харуулаач!” гэтэл “Болдоо чи өөрөө бодоорой” гэх багшийнхаа дууг сонсоод золтой л сандал дээрээсээ уначихсангүй. Тэр цаасны өөдөс авч дээр нь “Тоогоо харуулбал дахиад нэг шинэ дэвтэр өгье. Хоёр дэвтрээ би буцааж авахгүй” гэж бичээд Туяагийн өмнө тавьж орхилоо. Туяа бичгийг уншаад жуумалзсанаа толгой сэгсрэв. Болд багшийгаа хойд талын ширээ рүү явж өнгөрөхөд Туяа нударч “Би дэвтрээ авмаар байна” гэж шивнэлээ. Туяа Болдыг инээмсэглэн хараад, “Би завсарлагаанаар олж өгье!” гэв. Болд дахиад л “Би дэвтрээ одоо л авахгүй бол тоогоо бодож болохгүй байна” гэтэл багш нь түүнийг чимээгүй байхыг анхааруулав. Туяа тоогоо бодож дуусаад гарч явлаа. Болд бодлогоо бодохын оронд “Туяа ёстой хувиа бодогч! Чамайг завсарлагаанаар ангийнхандаа хэлж ганц сайн шоолъё гайгүй” гэж бодож суутал хонх дуугарав.

Завсарлагаанаар Болд;

-Нөхөд өө! Манай ангийн Туяа бол хувиа бодогч юм аа. Надаас дэвтэр гуйж аваад тоогоо харуулаагүй гэж хашхиран хөхрөхөд түүнийг дагаж хэн ч инээсэнгүй. Тэгэхээр нь Болдын хор хөдөлж Туяагийн дэргэд үсэрч очоод “Дэвтрээ авъя” гэж хэлж дуусаагүй байтал урд ширээнд суудаг Бүжин охин нэг шинэ дэвтэр авчирч өгөөд түсхийтэл инээд алдчихав. Дараагийнх нь цаг дээр тэдний ангид уран зохиолын хичээл оржээ. Гэтэл Болд зөрүүлдэж суугаад тохойгоороо номоо халхлан байдгаараа нугдайн ганцаараа уншиж, Туяа арынхаа ширээ рүү эргэж хараад уншиж байгааг харсан багш нь,

-Болд оо! Чи яагаад хувиа бодоод Туяад уншуулахгүй байгаа юм бэ? гэхэд анги дүүрэн инээд болов. Нөхдийнх нь жиг жиг инээх Болдод ичиг ичиг гэх мэт санагдаж нүүрнээс нь гал бутрах шиг болов.

Ж.Барамсай

Монгол хэлний даалгаврууд

1. Эхэд юуны тухай өгүүлж байна вэ?
 - A. Хувиа бодсон зангийн тухай
 - B. Тооны хичээлийн шалгалтын тухай
 - C. Хүүхдүүдийн инээлдсэн тухай
 - D. Болдоо Туяад дэвтэр өгсөн тухай
2. Эхийн өрнөсөн үйл явдлыг цаг хугацааны дарааллаар эрэмбэлээрэй.
 1. Туяа нэг ширээний Болдоос дэвтэр гуйсан.
 2. Туяа бичгийг уншаад жуумалзсанаа толгой сэгсрэв.
 3. Туяагийн дэвтэр дүүрчихсэн байв.
 4. Туяа тоогоо бодож дуусаад гарч явлаа.

A. 1, 3, 2, 4 B. 1, 2, 4, 3 C. 4, 1, 2, 3 D. 3, 1, 2, 4




3. Дараах өгүүлбэрүүдээс эхийн гол санааг илэрхийлснийг сонгоорой.
- A. Надаас дэвтэр гуйж аваад тоогоо харуулаагүй гэж хашхирав.
 - B. Болд оо! Чи яагаад хувиа бодоод Туяад уншуулахгүй байгаа юм бэ?
 - C. Тооны хичээл дээр бичгийн ажил хийх болжээ.
 - D. Болд цүнхнээсээ гурван шинэ дэвтэр гаргаад нэгийг нь өгөв.
4. Болдын ичсэнийг илэрхийлэх баримтыг сонгоорой.
- A. Надаас дэвтэр гуйж аваад тоогоо харуулаагүй гэж хашхиран хөхрөхөд түүнийг дагаж хэн ч инээсэнгүй.
 - B. Багшийгаа хойд талын ширээ рүү явж өнгөрөхөд Туяаг нударч “Би дэвтрээ авмаар байна” гэж шивнэлээ.
 - C. “Би дэвтрээ одоо л авахгүй бол тоогоо бодож болохгүй байна” гэтэл багш нь түүнийг чимээгүй байхыг анхааруулав.
 - D. Нөхдийн нь жиг жиг инээх Болдод ичиг ичиг гэх мэт санагдаж нүүрнээс нь гал бутрах шиг болов.
5. Шоолж буй өнгө аясыг илэрхийлсэн өгүүлбэр аль нь вэ?
- A. Ичиг ичиг гэх мэт санагдаж.
 - B. Сандал дээрээсээ уначихсангүй.
 - C. Түсхийтэл инээд алдчихав.
 - D. Байдгаараа нугдайн ганцаараа уншив.
6. “Надаас дэвтэр гуйж аваад тоогоо харуулаагүй гэж хашхиран хөхрөхөд түүнийг дагаж хэн ч инээсэнгүй” Хэрэв чи Болдын найз байсан бол энэ үед яах байсан бэ?
- A. Хамт инээж хөхөрнө.
 - B. Найзыгаа өмөөрнө.
 - C. Туяаг зэмлэж буруутгана.
 - D. Бусдын адил дуугүй сууна.
7. “Болд оо! Чи яагаад хувиа бодоод Туяад уншуулахгүй байгаа юм бэ” гэсэн багшийн үгийг лавшруулан дэлгэрүүлэх асуулт аль вэ?
- A. Та хоёр муудалцаа юу?
 - B. Болд оо! Чи номоо харамлахаа болиорой!
 - C. Хэн номоо харамлаад байгаа юм?
 - D. Найзаасаа номоо харамлах муухай шүү!
8. Хэрвээ Туяа завсарлагаанаар Болдод дэвтэр олж өгсөн бол юу гэж хэлж өгөх байсан бэ?
- A. Болд оо, дэвтрүүдээ аваарай.
 - B. Болд оо, дэвтрийг минь аваарай.
 - C. Болд оо, дэвтрийг нь аваарай.
 - D. Болд оо, дэвтрээ аваарай.
9. “байв, сууна, шивнэлээ, оржээ” гэх өгүүлбэр төгсгөх үйл үгсийг ажиглаад бусдаасаа өөр цаг зааж байгаа үгийг сонгоорой.
- A. сууна B. байв C. шивнэлээ D. орхижээ
10. Дараах цаг хугацааны утгат үгсээс хамгийн богино хугацааг заах үгийг олоорой.
- A. хойд ширээ рүү явж өнгөрөх
 - B. дараагийн цаг
 - C. тонгойх зуур
 - D. завсарлагаанаар




11. “Ангийн охин Бүжин нэг шинэ дэвтэр авчирч өгөв” гэсэн өгүүлбэрийн цөм бүтцийг тодорхойлоорой.
- A. Бүжин нэг дэвтэр авчирч өгөв.
 - B. Бүжин шинэ дэвтэр авчирч өгөв.
 - C. Ангийн охин дэвтэр авчирч өгөв.
 - D. Бүжин дэвтэр авчирч өгөв.


Үндэсний бичгийн даалгаврууд

12. “  ” холбоо үгийг зөв уншаарай.


- A. зураг зурах
- B. зориг зүрх
- C. зураг зөрөг
- D. зориг жирийх


13. “  ” өгүүлбэрийг зөв хөрвүүлснийг олоорой.

- A. Алтайн уулыг мориор давлаа.
- B. Алсын уулыг мориор дагалаа.
- C. Алтайн уулыг мориор дагалаа.
- D. Алсын уулын мөрөөр давлаа.

14. “  ” гэдэг үгэнд олон тооны тохирох дагаврыг сонгоорой.

A	B	C	D
			
			

15. “  ” цэгийн оронд харьяалахын тийн ялгалын нөхцөлийн тохирохыг сонгоорой.

A	B	C	D
			

16. “  ” гэх үгэнд эзэнд хамаатуулах нөхцөлийн зөвийг залгаарай.

A	B	C	D
			



Уран зохиолын даалгаврууд

17. “Хуур хөгжим үүссэн нь” монгол домгийн доорх хэсгийг уншаад, монгол үндэстний соёлын ямар зүйлс илэрч байгааг зөв сонгоорой.

“...Иклийг ч гэсэн, товшуурыг ч гэсэн Шуламс эхэлж хийсэн байгаа юм. Иклийг хийчхээд, харгайн давирхай түрхээд дуугаргасанд энэ хуур их чанга дуутай, чахтнаад, үг хэл огт орж ирэхгүй байжээ. Тэгээд Шуламс Бурхнаас очиж асуусан гэнэ”

- A. икэл, товшуур, шуламс
- B. товшуур, хуур, шуламс
- C. икэл, товшуур, хуур
- D. товшуур, хуур, давирхай

18. П.Бадарчийн “Есөн эрдэнийн орон” шүлгийн

“Өргөн талын элгэнд чандманиланхан буусан

Өргөө гэрүүд минь танан өнгөөр цавцайна” хэсэгт юуг юутай, ямар шинжээр нь адилтган бичсэн байна вэ?

- A. тана эрдэнийг гэртэй цагаан өнгөөр нь адилтгасан
- B. гэрийг тана эрдэнэтэй хатуу шинжээр нь адилтгасан
- C. гэрийг тана эрдэнэтэй цагаан өнгөөр нь адилтгасан
- D. тана эрдэнийг гэртэй хатуу шинжээр нь адилтгасан

19. Жинд явах үйл явдал гардаг зохиол аль вэ?

- A. Д.Даваанямын “Зүрх цагаан”
- B. Ш.Гаадамбын “Шаргачин”
- C. П.Хорлоогийн “Алт, мөнгө хоёр”
- D. Л.Одончимэдийн “Хүүхдийн бор”

20. Жамбын Дашдондогийн “Аранзал зээрд” шүлгийн хэсгийн толгой холбоцыг тодорхойлоорой.

- | | |
|---------------|----------------------------|
| Талаар талаар | A. AABV - хос холбоц |
| Ташуур өгөн | B. ABAB - салаалсан холбоц |
| Ташуур өгөн | C. AAAA - бүрэн холбоц |
| | D. ABBA - хашсан холбоц |